**МОНГОЛ УЛС**
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2011 оны 09 сарын 14 өдөр Дугаар 266 Улаанбаатар хот

┌ “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ┐
үйл ажиллагааны тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8.2, 12.10, 14.9, 19.10, 20.4, 27.2, 30.3, 32.2, 36.2, 40.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ыг хавсралтаар баталж, 2011 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН